

ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дархан-Уул аймгийн Хүүхдийн номын ордны 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ДАА-2022/10/НА-СА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn Дархан-Уул аймаг 2022 он	Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторын албан үүргийн түр орлон гүйцэтгэгч: Ш.Мөнхбаяр Утас: 70378845 Цахим хаяг: munkhbayarsh@audit.gov.mn Ахлах аудитор: С.Батцэцэг Утас: 70373089 Цахим хаяг: battsetsegs@audit.gov.mn Аудитор: О.Мягмарсүрэн Утас: 70373089 Цахим хаяг: myagmarsureno@audit.gov.mn
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу



ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

45059 Дархан-Уул аймаг,
Дархан сум, 14-р баг
Утас: 7037-3089, Факс: (976) 7037-3089
E-mail: darkhanuul@audit.gov.mn

ДАРХАН-УУЛ АЙМГИЙН ХҮҮХДИЙН
НОМЫН ОРДНЫ ЗАХИРАЛ Л.МӨНХБААТАР
ТАНАА

2022.02.11 № 62
танай _____-ны № _____-т

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ



Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дархан-Уул аймгийн Хүүхдийн номын ордны 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дархан-Уул аймгийн Хүүхдийн номын ордны 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Ш.МӨНХБАЯР



009020044

Нэг. Санхүүгийн ба төсвийн гүйцэтгэлийн тайлангийн гол үзүүлэлтүүд

(төгрөгөөр)

Дансны код	Балансын үзүүлэлт	2020.12.31	2021.12.31
Санхүүгийн байдлын тайлан			
	Эргэлтийн хөрөнгийн дүн	8,456,002.00	4,530,850.00
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	526,555,524.56	535,869,826.65
	Нийт хөрөнгийн дүн	535,011,526.56	540,400,676.65
	Нийт өр төлбөрийн дүн	-	-
	Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	535,011,526.56	540,400,676.65
	Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн	535,011,526.56	540,400,676.65
Санхүүгийн үр дүнгийн тайлан			
	Үйл ажиллагааны орлогын дүн	233,980,400.00	298,196,300.00
	Үйл ажиллагааны зардлын дүн	244,504,218.31	292,807,149.91
	Үйл ажиллагааны үр дүн	(10,523,818.31)	5,389,150.09
	Үйл ажиллагааны бус үр дүн	896,324.41	0.00
	Үйл ажиллагааны нийт үр дүн	(11,420,142.72)	5,389,150.09
Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан			
	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	547,380,718.69	535,011,526.56
	Тайлант оны үр дүн	(11,420,142.72)	5,389,150.09
	Эцсийн үлдэгдэл	535,011,526.56	540,400,676.65
Мөнгөн гүйлгээний тайлан			
	Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	227,839,400.00	289,024,300.00
	Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн	224,629,200.00	268,573,000.00
	Үйл ажиллагааны ЦМГ	3,210,200.00	20,451,300.00
	Хөрөнгө оруулалтын ЦМГ	(3,210,200.00)	(20,451,300.00)
	Санхүүгийн ажиллагааны ЦМГ	-	-
	Нийт цэвэр мөнгөн гүйлгээ	-	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-
Төсвийн гүйцэтгэлийн тайлан			
	Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	287,776,800.00	268,872,183.57
	Урсгал зардал	287,776,800.00	268,872,183.57
	Хөрөнгийн зардал	-	-
	Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр	287,776,800.00	269,459,683.57
	Улсын төсвөөс санхүүжих	287,176,800.00	268,272,183.57
	Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас	600,000.00	1,187,500.00

Хоёр. Байгууллага, түүний үйл ажиллагаа

Хүүхдийн номын ордон нь аймгийн хүүхэд, залуучуудад номын сангийн үйлчилгээ үзүүлдэг байгууллага бөгөөд "Ирээдүйн уншигчдыг хөтөлнө, Оюунлаг Дарханчуудыг бүтээнэ" гэсэн эрхэм зорилготой үйл ажиллагаагаа явуулж байна.

Гурав. Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Төсвийн шууд захирагч үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал, санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй.

Дөрөв. Аудитын гол асуудал

Дархан-Уул аймгийн Хүүхдийн номын ордны 2021 оны санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудал байхгүй.

Тав. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

Зургаа. Дараагийн аудитаар анхаарах асуудал

Анхны өртгөө элэгдлээрээ бүрэн нөхсөн 0 үлдэгдэлтэй 34,824.5 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө бүртгэлтэй байгаа тул цаашид ашиглах боломжтой хөрөнгийн үнийг шинэчлэн тогтоосон эсэхийг дараагийн аудитаар авч үзэх нь зүйтэй гэж үзлээ. **Долоо.**

Аудитын илрүүлэлт:

Аудитаар нийт 19,746.6 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрсэнд 2 зөвлөмж өгсөн.

7.1 Залруулсан алдаа

Залруулсан алдаа байхгүй.

7.2 Төлбөрийн акт

Аудитаар төлбөрийн акт тогтоох зөрчилтэй асуудал гараагүй болно.

7.3 Албан шаардлага

Албан шаардлага хүргүүлэх зөрчилтэй асуудал гараагүй болно

7.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Үндсэн хөрөнгөтэй холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Дахин үнэлгээний нэмэгдэл 314,113.9 мянган төгрөг санхүүгийн тайланд бүртгэлтэй боловч үндсэн хөрөнгийн дэлгэрэнгүй бүртгэлд 296,285.2 мянган төгрөг буюу 17,828.7 мянган төгрөгөөр дутуу тусгагдсан нь аль хөрөнгөд хамаарах нь тодорхойгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т "Үнэн зөв байх", Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар батлагдсан "Нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ын Дахин үнэлгээ 4.42-д "Дахин үнэлгээний үр дүнд хөрөнгийн дансны үнэ нэмэгдсэн хэмжээгээр дахин нэмэгдэл дансны кредитэд бичнэ", 3 дугаар хавсралт "Төсөвт байгууллагын санхүүгийн тайлан бэлтгэх заавар"-ын 4.20-д "Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээгээр гарсан үнийн өсөлтийг "Дахин үнэлгээний нэмэгдэл" гэсэн хэсэгт үзүүлнэ" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

1.2. Өгсөн зөвлөмж:

Үндсэн хөрөнгийн дэлгэрэнгүй бүртгэлд хөрөнгө тус бүрт хамаарах дахин үнэлгээний нэмэгдлийг тусган оруулж, данснаас хасагдсан хөрөнгөд хамаарах дахин үнэлгээний нэмэгдлийг УССНБОУС 17 Үндсэн хөрөнгө стандартын 57-д заасны дагуу хасалт хийж, үлдэгдлийг үнэн зөв тайлагнах

2. Цалингийн зардлын данстай холбоотой асуудал

2.1. Илрүүлэлт:

Тайлант онд батлагдсан цалингийн зардлаас ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэлд 544.8 мянга, тэтгэвэрт гарсан албан хаагчдад нэг удаагийн тэтгэмж 1,233.2 мянга, шагналын дагалдах мөнгөн шагнал 140.0 мянга, нийт 1,917.9 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах” гэж заасантай нийцэхгүй байна.

2.2. Өгсөн зөвлөмж:

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалаар баталсан “Зардлын эдийн засгийн ангилал, заавар”-ын дагуу батлагдсан төсвийг зарцуулах, холбогдох хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Найм. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн мэдээлэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1	1			1			
2	Төсөл, хөтөлбөр								
3	ЗГТС								
4	ТТЗ								
5	ТЕЗ								
	НИЙТ	1	1			1			

8.1 Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл:

(сая төгрөгөөр)

№	Төсвийн захирагчийн ангилал	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
A	1	2	3	4	5	6	7	8	9	10	11
1	ТШЗ	2	19.7	-	-	-	-	-	-	2	19.7
2	Төсөл, хөтөлбөр	-	-	-	-	-	-	-	-	-	-
3	ЗГТС	-	-	-	-	-	-	-	-	-	-
4	ТТЗ	-	-	-	-	-	-	-	-	-	-
5	ТЕЗ	-	-	-	-	-	-	-	-	-	-
	НИЙТ	2	19.7	-	-	-	-	-	-	2	19.7